

МОНГОЛ НУТАГ ДАХЬ УЙГУРЫН ҮЕД ХОЛБОГДОХ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛУУДЫН ТОЙМ

Б.АЗЗАЯА

МУИС, ГХСС, Түрэг судлалын тэнхим

e-mail: centreturkicamongol@yahoo.com; azzaya@num.edu.mn

Түлхүүр үгс: Монгол нутаг, уйгурын үе, руни бичгийн дурсгал,

Өгүүллийн товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол нутаг дахь гэрэлт хөшөө, хад чулуунаа буй бичгийн дурсгалуудаас түүхэн он цагийн хувьд зөвхөн уйгур (744-840)-ын үед холбогдох руни бичгийн дурсгалын танилцуулга, судалгааны тоймыг толилуулж байна.

Төв Азид Түрэг (552-744), Уйгур (744- 840), Киргиз (840- 910) зэрэг түрэг угсаатны төр улсууд оршин тогтнож байсан билээ.

Эрдэмтэд түрэг, уйгур, киргизийн үеийн, он цаг, үе нь тодорхойгүй бичээс хэмээн ангилсаар ирсэн түүхтэй. Бид энэ удаад, Монгол нутаг дахь гэрэлт хөшөө, хад чулуунаа буй руни бичгийн дурсгалуудаас түүхэн он цагийн хувьд зөвхөн уйгурын үед холбогдох руни бичгийн дурсгалыг тусгайлан танилцуулахыг зорилоо.

Одоогийн байдлаар Уйгурын үед холбогдох руни, уйгур бичгийн дурсгал 29 газраас нийтдээ 60 гаруй илрээд байна.

Монголын руни бичгийн дурсгалуудыг сонгодог, бага бичгийн дурсгалууд хэмээн ангилдаг бөгөөд Уйгурын үеийн сонгодог бичгийн дурсгал буюу гэрэлт хөшөөний бичээс 4, хөшөөний бичээс 2, чулууны бичээс 2, мэлхий чулуун суурийн бичээс 1, зоосны бичээс 1, нумын наалт дээрх бичээс 1, харин бага бичгийн дурсгал болох хадны бичиг 30 орчим байна.

Бичиж үйлдсэн арга, барил, бичлэгийн тиг хэлбэр, үзэгдэх байдлаар (Баттулга, 2005: 41-54) нь авч үзвэл сонгодог, хичээнгүй цохимол бичээс 4, цохимол бичээс 8, бэхэн бичээс нижгээд бусад нь зураасан буюу зурчмал бичээс байна. Монголын руни бичгийн бага дурсгалууд, нэн ялангуяа Уйгурын үеийн бичээсийг судлагч эрдэмтдэд хэрэг болох буй за хэмээн эл үед хамаарах бичээсийн судалгааг товч толилуулж байна. Хэдийгээр зарим бичээс уйгурын үед баттай холбогдох эсэх нь маргаантай ч цаашид түрэг судлаачид лавшруулан судалж нягтална гэдэгт найдна.

Бичээсүүдийн судалгаа:

1. Алтан хадны бичээс

Говь- Алтай аймгийн Бигэр сумын төвөөс зүүн хойш 13 орчим км-т Алтан хад хэмээх багаватар өвөлжөөний хаданд руни бичгийн хоёр мөр дурсгал байгааг түрэг судлаач Ц. Баттулга 2005 онд илрүүлж улмаар уншиж тайлсан судалгаагаа нийтлүүлсэн байна (Баттулга, 2005А; Баттулга, 2006: 53-59).

2. Ар ханангийн бичээс

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын төвөөс урагш 40 орчим км-т Арханан гэх нэгэн багавтар уулын арын өвөлжөөний бичээсийг судлаачид “Арханангийн түрэг бичээс” хэмээн нэрлэж тэмдэглэсээр иржээ. Ойролцоогоор 16 м орчим үргэлжлэх ханан хаднаа эл бичээс буй аж.

Эл бичээсийг анх Польшийн нэрт эрдэмтэн Е.Трыарски 1964 онд тайлан уншсан (Tryjarski, 1965: 423-428) ба түүний дараа О.Намнандорж (Намнандорж, 1966: 38-41), академич Б.Ринчен (Rintchen, 1968: 37) зэрэг эрдэмтэд гэрэл зургийг нь нийтлүүлэн шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ. Хожим С.Харжаубай (Каржаубай, 1980: 90-93), С.Г.Кляшторный, Е.Трыарски нар (Kljaštornyj, Tryjarski, 1990: 65-68) уг бичээсийг дахин нягтлан уншсан судалгаагаа нийтлүүлжээ.

Түрэг судлаач Ц.Баттулга 2005 онд уг бичээсийг судлан уншлага, тайлбар сэлтийн хамт хэвлүүлсэн байна. Тэрбээр “... Удаа дараагийн судалгааны дүн, бидэнд байгаа хэв дардсаас үзэхэд уг гурван мөр бичээс нийтдээ 132 үсэг тэмдэгтээс бүрдэж байна. Бичээсийн I мөр 105 см урт, 83 үсэгтэй, II мөр 36 см урт, 26 үсэгтэй, III мөр 25 см урт, 23 үсэгтэй ажээ” хэмээн тэмдэглэжээ (Баттулга, 2005: 115-121).

3. Бага Ойгорын бичээс

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Бага Ойгор хэмээх уулнаа байх энэхүү ганц мөр бичээсийг Монгол-Америк-Оросын хамтарсан “Эртний Алтай” төслийнхэн илрүүлж тайландаа мэдээлсэн байна (Jacobson-Tepfer, Kubarev, Tseveendorj, 2006).

Ц.Баттулга Бага Ойгорын бичээсийг проф. Д.Цэвээндорж нарын гар хуулбарт тулгуурлан анх уншиж тайлан судалгааны эргэлтэд оруулсан байна (Баттулга, 1998). Хожим тэрбээр бичээсийг нүдээр үзэж дахин нягталсан ажээ. Энэхүү бичээсийг 90 см өндөр, 1.50 см өргөн, 4.21 см урт үхэр хадан дээр хүрлийн үед холбогдох нижгээд зургийн хажууд сийлсэн байна. Бичээсийг хурц үзүүртэй зүйлээр маш өнгөцхөн зурж бичсэн тул дардас авах боломжгүй, ... Эл ганц мөр бичээснээ дайн тулаан, баатарлаг үйл хэрэг болоод алдар цуут нэгний дурсгалд зориулаагүй, ан ав хийсэн, аян замаар зорчин явсан тухайгаа бичээгүй, харин баялаг сайхан нутагт сэтгэл хангалуун амьдарч буйгаа тэмдэглэн үлдээсэн ажээ.

4. Бигэрийн I, II, III, IV, V, VI, VII бичээс

Бигэрийн бичээсийг Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх соёлын шинжилгээний ангийн бичээс судлалын хэсэг 1969 онд олж илрүүлсэн ажээ (Шинэхүү, 1971: 37-39).

Бичээсийг М.Шинэхүү гуай анх судалж эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн (Шинэхүү, 1971: 37-39) бөгөөд эрдэм шинжилгээний болон бусад ном зохиолд түүний уншлага судалгааг голлон ашигласаар ирсэн байна (Дашбадрах, 1999: 205). М.Шинэхүү гуай нийтдээ дөрвөн бичээсийн үсэг, үгийн галигийг мөн бичээс тус бүрийн утгыг монгол бичгийн хэл болоод хасаг, манж хэлнээ харгуулан орчуулж хадсан ажээ.

М.Шинэхүү гуайн энэхүү судалгааг проф. Л.Болд бүтээлдээ оруулж зарим бичээсийг өөрөөр унших санал дэвшүүлжээ (Болд, 1990: 21-22). 2005 онд Ц.Баттулга Бигэрийн бичээсийг дахин нягталж уншсанаас гадна шинээр гурван бичээс илрүүлжээ¹.

Бигэрийн I

¹ Ц.Баттулга, Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутаг дахь эртний бичээс, ARC-ийн тайлан. МУИС, Гадаад хэл соёлын сургууль, Түрэг судлалын төв, гар бичмэлийн сан хөмрөг.

Бигэрийн нэгдүгээр бичээс нь хоёр мөр юм. М.Шинэхүү абугай бичээсийн утгыг монгол бичгийн хэл болон хасаг, манж хэлтэй харьцуулан орчуулсан байна. Ц.Баттулга эл бичээсийн үсэг тэмдэгтийг мадагтай хуулсанаас мадагтай болжээ хэмээн үзжээ.

Бигэрийн II

Нэг мөрөөс бүтэх бичээсийг М.Шинэхүү гуай хоёрдугаар үсэг W (η) –ийг 1 (L) хэмээн ташаарснаас уншлага судалгаа мадагтай болжээ гэж Ц.Баттулга үзсэн байна.

Бигэрийн III

Ганц мөрөөс бүтэх эл бичээсийг М.Шинэхүү, Ц.Баттулга нар үсэг тэмдэгтийн ямар нэгэн зөрөөгүй буулгасан боловч утгын хувьд бага зэрэг ялгаатай орчуулжээ.

Бигэрийн IV

Нэг мөр эл бичээсийг М.Шинэхүү Ptivnm гэж харин Ц.Баттулга Wbivnn хэмээн нэлээдгүй зөрүүтэй буулгаж уншсан байна. Бичээсийн үсэг тэмдэгт зөрөөтэй тул бичээсийн утга, уншлага ч нэлээд ялгаатай болжээ.

Бигэрийн V

М.Шинэхүү гуайн судалгаанд огт дурдагдаагүй, гурван үсэг тэмдэгтээс бүтэх ганц мөр энэ бичээс нь сайн ажиглахгүй бол мэдэгдэхээргүй зураасан бичиг юм. Бичээсийг Ц.Баттулга mll (Y L m) yalpm- нэгд, эгц, цавчим, хоёрт, yalma - хуяг, хуягт дээл гэсэн утгатай хэмээн тайлан уншсан байна.

Бигэрийн VI бичээс

Ц.Баттулга анх илрүүлж тайлан уншсан байна. Бичээсийн эхлэл хэсэг бүхий хад нь хагарч уншсан тул эл ганц мөр бичээсийн утга бүрэн бус ажээ. Тэрээр KIX (...GYQ)...ү аура буюу ...-ыг сард гэсэн хэмээн уншсан байна.

Бигэрийн VII бичээс

Дээрх бичээс бүхий Бичигтийн өвөлжөөнөөс саахалтын зайтай, болдог толгойн энгэрийн хаданд хоёр үсэг, нижгээд тамга буй ажээ. Ц.Баттулга эл бичээсийг Бигэрийн VII бичээс хэмээн тэмдэглэсэн байна.

5. Бөмбөгөрийн бичээс

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын төвөөс баруун өмнө зүгт, 11 орчим км-т Тайн нурууны төгсгөл, Шивээт хэмээх намхан уулнаа буй гэрэлт хөшөөг “Бөмбөгөрийн бичээс” хэмээн нэрлэдэг байна. Цайвар шаргал боржин чулуун хөшөөний магнайд 4 мөр бичээс байх бөгөөд хөшөөний оройн хэсэг холцрон унасан тул мэдэгдэж буй дөрвөн мөрөөс дээш тамга болоод бичиг байсан эсэх нь тодорхойгүй, харин хөшөөний баруун хажууд мөн нэг мөр бичээс буйн эхний хоёр үсгийн дараагийн гурав, дөрвөн үсэг холцорч унасан хэдий ч бусад үсэг тэмдэгтүүд маш тод ажээ. Уг хөшөө тахилга булшны овоолго чулуунд нөмөрлөгдөж, тал хэсэг нь далд дараастай байсан тул бичээсийн үсэг тэмдэгтүүд харьцангуй сайн хадгалагдан үлдсэн байна (Баттулга, 2005б:117-124).

Уг бичээсийг анх Ц.Баттулга уншиж тайлсан (Баттулга, 2005: 122-128; Баттулга, 2005б: 117-124) ба Японы эрдэмтэн Сузукигийн судалгаа бий.

6. Гурвалжин уулын бичээс

Булган аймгийн Гурванбулаг сумаас зүүн өмнө зүг 17 км-т Гурвалжин нэрт багахан шовх уулын бэлд, Тарнын голын баруун талд нэг мөр бичээс буйг судлаачид “Гурвалжин уулын бичээс” гэж нэрлэсээр иржээ.

Гурвалжин уулын бичээс нь 130 х 98 см хэмжээтэй саарал боржин чулуун дээр маш тодорхой, гаргацтай бичсэн, цохимол бичээс юм.

Нийтдээ 70 см урт бичээсийн эхний үсэг 7 см, төгсгөлийн үсэг 11 см өндөр бөгөөд 13 үсэг тэмдэгттэй, үсгийн зурлага бичлэгийн хэлбэр тогтсон, харьцангуй хичээнгүй, бичээсийн дээд талд хоёр тамга сийлсэн байдаг ажээ.

Эл бичгийн дурсгалыг анх мэргэн гүн Мөнх-Очирын Гомбожав гар хуулбар хийж Судар бичгийн хүрээлэнгийн захирал байсан Жамсрангийн Цэвээн гуайд өгсөн бөгөөд тэрбээр 1929 онд Оросын эрдэмтэн А.Н.Самойловичид энэ бичээсийн гар хуулбарыг илгээсэн байна. А.Н.Самойлович хүргүүлсэн хуулбарт тулгуурлан “teŋgi qulp bitidim-Тэнгэрийн боол бичив би” гэсэн утгатай болохыг тайлж 1934 онд хэвлүүлсэн ажээ (Самойлович, 1934). Х.Н.Орхун, О.Намнандорж, академич Б.Ринчен нар мэдээлж (Orhun, 1938: 161-162; Намнандорж, 1966: 38-41; Rintchen, 1968: 37), Б.Базылхан, С.Г.Кляшторный нар (Базылхан, 1969: 14-15; Кляшторный, 1975: 155; Кляшторный, 2003: 274-275) уг бичээсийг дахин уншиж судалсан байна. Л.Болд “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс” бүтээлдээ (Болд, 1990: 23-24) оруулжээ.

Хожим түрэг судлаач Ц.Баттулга уг бичээсийн судалгааны тойм, тайлбар сэлтийг өөрийн бүтээлдээ нийтлүүлжээ (Баттулга, 2005: 129-131).

7. Гурванмандалын бичээс

Дундмандалын бичээс, Адагмандалын бичээс

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт оройг нь тэгшилж тайрсан мэт нэн өвөрмөц тогтоц бүхий сөнөсөн гурван галт уул буйг “Мандал Хайрхан” буюу Гурван Мандал хэмээн нэрлэдэг байна. Гурван Мандал уул сумын төвөөс 42 орчим км-т баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон, Эхэн Мандал, Дунд Мандал нь хормой нийлэн орших ба харин Адаг Мандал нь хол саахалтын зайтай байх ажээ. Уулын оройн, толигор хар өнгийн ханан хаднаа олон зүйл зураг, тамга, руни бичиг сийлжээ. 1987 онд ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Дашцэвэл, Р.Бямба нар Гурван Мандалын дурсгалыг анх олж судлаач нарт мэдээлсэн байна (Болд, Бямба, 1988: 103-108). Гурван Мандал уулын бичээсийг доктор Л.Болд (Болд, 1990: 25-27), хадны зураг, тамга, тэмдгийг Д.Баяр (Баяр, 1996: 89-102) тухайлан судалжээ.

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал номд “Гурван Мандалын бичээс”-ийг Л.Болд гуайн уншлага, орчуулгаар оруулсан байна (Монгол нутаг дахь ..., 1999: 207).

Хожим доктор Ц.Баттулга Дунд болон Адагмандалын бичээсийг шинээр уншиж тайлсан судалгаагаа өөрийн бүтээлдээ оруулжээ (Баттулга, 2005: 132-135).

8. Далан уулын бичээс

1982 онд Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Далан уулнаа археологийн хайгуул судалгаа хийсэн эрдэмтэд руни бичгийн нэг мөр дурсгал олж улмаар урьдчилсан байдлаар уншсанаа тайландаа танилцуулжээ.

Археологич Г.Мэнэс дээрхи тайландаа “Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг “Далан” уулын өмнө биеийн нэгэн салбар жалганаас ганц мөр түрэг бичээсийг оллоо. Уг бичээсийн урт нь 65 см, үсэг зурлагын өндөр нь 6.5 см, өргөн нь 0.9 см. Хадан толгойн дээд хэсэгт наран тал руу харсан нэгэн хавтгай хаданд сийлсэн байна” хэмээн тэмдэглэжээ (Мэнэс, 1982: 25). Доктор Ц.Баттулга өөрийн бүтээлдээ уг бичээсийн талаар дурдсан бөгөөд бичээсийн уншлага, орчуулгыг өгүүлэл болгон хэвлүүлжээ (Баттулга, 2005: 104-108; Баттулга, 2007: 90-92).

9. Долоогийдойн бичээс

Увс аймгийн Түргэн сумын нутаг Хар-Ус хэмээх газар, нутгийнхны нэрлэж заншсанаар “Долоогойдойн булш” гэх томоохон хиргисүүрээс энэхүү дурсгалыг 1955 онд археологч Ц.Доржсүрэн олж илрүүлжээ (Доржсүрэн, 1957: 25). Улаан хүрэн өнгийн хоёр хөшөө чулууны нэгэнд нь руни, нөгөөд нь уйгур бичээс буй бөгөөд эдүгээ тус аймгийн орон нутаг судлах музейд хадгалагдаж байна. Анх академич Б.Ринчен бүтээлдээ уг хоёр хөшөөний гэрэл зургийг хэвлүүлжээ (Rintchen, 1968: 41). С.Г.Кляшторный руни бичигт хөшөөний урьдчилсан судалгаа, он цагийн хамаарал, түүхэн үйл явдлын талаар дурдсан (Кляшторный, 1961: 26-28; Кляшторный, 2003: 282-288) бол нэрт түүхч Л.Н.Гумилев гэрэлт хөшөөний бичээсийн түүхэнд холбогдох талаас нь өгүүлжээ (Гумилев, 1963: 24).

Дурсгалын уйгур бичээсийг Оросын эрдэмтэн А.М.Щербак анх тайлан уншсаныг (Щербак, 1961: 23-25; Щербак, 2001: 120-126) Э.Вандуй монгол хэлнээ хөрвүүлжээ (Вандуй, 1958: 45-47). Руни бичээсийг эрдэмтэн Б.Напил уншиж галиглан, казак хэлнээ (Базылхан, 2005: 160-161), түрэг судлаач Ц.Баттулга, Н.Гэрэлмаа нар дахин нягталж галиг, монгол орчуулга, үгийн тайлбарыг хийсэн байна (Баттулга, Гэрэлмаа, 2007: 262-267).

10. Зоосны бичээс

Энэхүү дурсгалыг археологч Н.Сэр-Оджав гуай 1961 онд Дорнод аймагт хийсэн археологийн хайгуул, шинжилгээний ажлын явцад олж илрүүлсэн (Сэр-Оджав, 1977: 41-42) бөгөөд бичээсийг С.Г.Кляшторный анх уншиж судалсан байна (Кляшторный, 1973: 335-338).

Түүний дараагаар С.Харжаубай (Харжаубай, 1979: 32), академич Л.Болд (Болд, 1990: 31-33), Ц.Баттулга (Баттулга, 2005: 52) нарын эрдэмтэд, харьцуулалт, уншлага судалгаагаа хэвлүүлсэн байна.

11. Зүүн оройн өвөлжөөний бичээс

Эл бичээсийг 1995 онд Монгол-Америк-Оросын хамтарсан “Эртний Алтай” төслийн хээрийн шинжилгээний анги анх олж илрүүлжээ (Jacobson-Tepfer, Kubarev, Tseveendorj, 2006). Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг, Бага Ойгор уулнаа эл ганц мөр бичээс бий. Хурц үзүүртэй зүйлээр зурж бичсэн энэхүү бичээс нь нийтдээ 19 үсэг тэмдэгтээс бүтэх бөгөөд үсгийн өндөр нь 2-3.5 см юм. Уг бичээсийг проф. Д.Цэвээндорж, доктор Ц.Баттулга нар уншиж тайлснаа хэвлүүлсэн байна (Цэвээндорж, Баттулга, 1999: 91-93).

12. Зүрх уулын бичээс

Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын төвөөс 40 гаруй км-т Хар магнайн хөндийн урд Хөшөөт хэмээх том уулын салбар Зүрх уулнаас археологч Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар 1989 онд олж илрүүлжээ (Баяр, Эрдэнэбаатар, 1989). Доктор Д.Баяр Монгол Алтайгаас шинээр олж илрүүлсэн бичээсүүдийн талаарх өгүүлэлдээ Зүрх уулын бичээсийн талаар анх мэдээлсэн ажээ (Баяр, 1990). Археологч Д.Эрдэнэбаатар 1990 онд уг бичээсийг дахин нягталж улмаар анх хуулсан хийгээд Д.Баяр гуайн нийтлүүлсэн эхэд алдаа мадаг гарсныг залруулан 1994 онд дахин мэдээлсэн байна (Эрдэнэбаатар, 1994). Түрэг судлаач, доктор Ц.Баттулга өөрийн уншлага судалгаагаа хэвлүүлсэн байна (Баттулга, 1998: 89-90).

13. Их бичигтийн бичээс

Их бичигтийн бичээсийг доктор Ц.Баттулга уг газарт нь очиж судалсан байна. Тэрбээр, Дундговь аймгийн төвөөс зүүн хойш 110 гаруй км-т, Говь-Угтаал сумын 2-р багийн нутагт Их бичигт, Бага бичигт хэмээх нэртэй газар байх бөгөөд

Их Бичигтийн өвөлжөөний байц хадыг голлон 180 см өндөрт нэг мөр руни бичээс, түүний дор залгуулан хоёр уйгур үг, түүнчлэн он цагийн хувьд эрт үед холбогдох морьтой хүний дүрс зураг буй хэмээн тэмдэглээд эдгээр бичээс, дүрс зургийг улаан хүрэн өнгийн хаднаа бичсэн нь улаан хүрэн өнгө түрхэц төдий өнгөцхөн тул үсэг цохихын хирээр цайвар цагаан өнгө тодорч улаан хүрэн дээр цагаанаар бичсэн мэт, ялангуяа түрэг бичээс их тод харагддаг (Баттулга, 1997А: 9-13; Баттулга, 1997) байна.

Их Бичигтийн хоёрдугаар бичээс

Түрэг судлаач Ц.Баттулга “Их Бичигтийн бичээст хадны зүүн талд мөн бичээс байсны ул мөр буй бөгөөд сайн мэдэгдэхээс S (s) r (R) I (Y) [I (Y) r (R) S (s)] үсгүүд тодорхой харагдана. Хожмын цагт судлаар хүрэгсэд дахин нягтлан үзэхэд тус санаж “Их Бичигтийн хоёрдугаар бичээс” хэмээн тодотгон нэрлэв. Хонон өнжин сууж, сайн багаж техникийн тусламжтайгаар нягтлан үзвэл уул бичээсийг унших боломж буйг тэмдэглэе” хэмээн тодорхойлсон байна (Баттулга, 2005: 158-161).

14. Их Хануй нуурын бичээс

Их Хануй нуурын тахилын байгууламжит дурсгал Эрдэнэмандал сумын төвөөс баруун урагш 9 орчим км-т, Хануй нуураас холгүй тэгш талд оршино. Уул тэгш талбайг хагалж тариа тарьсанаас эл дурсгал эдүгээ тарилангийн талбай дунд оржээ.

Их Хануй нуурын гэж алдаршсан, тахилын хавтан чулуунаа бүхүй бичээс хоёр хэсгээс бүтэх бөгөөд нэгдүгээр бичээсийг дугуйруулан бичсэн байх ба харин хоёрдугаар бичээсийн төгсгөл хэсэг л тодорхой үлдэж бусад хэсэг судалгааны эргэлтэд орохоос өмнө хугарч алга болжээ. Тахилын хавтан чулуун дээр холцруулан цохиж бичсэн эл хоёр хэсэг бичээсийн үсэг тэмдэгт маш тодорхой тул үсэгзүйн маргаан огт үгүй ч судлаачдын орчуулга багагүй зөрөөтэй ажээ.

Оросын ШУА-аас В.В.Радловоор удирдуулан илгээсэн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан археологич Д.А.Клеменц 1891 онд анх энэ дурсгалыг илрүүлсэн ба С.М.Дудин археологийн товч тодорхойлолт бичжээ (Radloff, 1894; 1987: 259; Радлов, 1892: 1-12; Клеменц, 1893). Мөн түүнчлэн Финийн нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт, Сакари Пэлсийн (Sakari Pdlsi), Б.Бамбаев, В.Войтов, доктор Д.Баяр зэрэг эрдэмтэд (Ramstedt, 1978; Memoria Saecularis Sakari Pdlsi, 1982: 182; Бамбаев, Ф-IX, Т.10, ХН.20-21; Войтов, 1996: 114-115; Баяр, 1997: 96) археологийн үүднээс, харин бичээсийг анх В.Радлов (Radloff, 1894; 1987: 259), хожим Х.Н.Орхун (Orhun, 1938; 1987: 103), С.Г.Кляшторный, Такаши Оосава (Takashi Ōsawa), Л.Болд нарын эрдэмтэд судлан (Кляшторный, 1978: 238-256; Takashi Ōsawa, 1999: 137-140; Болд, 2000: 232) бүтээлдээ нийтлүүлжээ.

15. Могойн шинэ усны дурсгал (Моюн-чурын гэрэлт хөшөөний бичээс)

Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт эл бичээсийг одоогийн Булган аймгийн Сайхан сум, Архангай аймгийн Хайрхан сумын зааг нутаг, Могойн шинэ ус хэмээх газраас илрүүлэн “Сэлэнгийн чулуу” гэж нэрлэн уншиж судалсан (Рамстедт, 1914; Рамстедт, 1914а; Ramstedt, 1913; Ramstedt, 1978; Ramstedt, Гранц, Aalto, 1958) байна. Хожим Моюнчурын хөшөө, Могойн шинэ усны бичээс гэх зэргээр нэрлэх болжээ.

Орой, углуургыг оруулаад нийтдээ 394,5 см өндөр бөгөөд өдгөө хоёр хэсэг болон хугарч унажээ. Он цагийн уртад нар, салхинд идэгдэн тамгатай нүүрэн хэсгээс бусад талын үсгүүд ихээр элэрч долорсноос зарим хэсэгтээ бараг үсэггүй болжээ. Томоохон хиргисүүрийн өмнө, мэлхий чулуунд суурилуулан босгосон эл

гэрэлт хөшөөний бичээсийг Н.Орхун, С.Е.Малов, Г.Айдаров, Т.Мориясу нарын эрдэмтэд судалжээ (Orhun, 1936-1994: 161-185; Малов, 1959: 30-44; Айдаров, 1971: 339-352; Takaо Moriyasu, 1999: 177-196). Мөн С.Пэлси, В.Өгэл, Е.И.Убрятова, Б.Базылхан нарын эрдэмтдийн тайлан, тойм судалгаа (Memoria Saecularis Sakari Rdlsi, 1982; Цгел, 1951; Убрятова, Базылхан, 1963: 71-74) байдаг ажээ.

16. Сүүжийн давааны бичээс

Нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт 1909 онд одоогийн Булган аймгийн Сайхан сумын орчим Сүүжийн даваа гэх газраас илрүүлсэн бөгөөд түүнээс хойш хэн ч энэ бичээсийг дахиж үзээгүй байна. Сүүжийн давааны бичээсийг Г.И.Рамстедтийн авсан эхэд тулгуурлан С.Е.Малов, Г.Айдаров, Л.Болд нарын эрдэмтэд судалжээ (Малов, 1959: 76-77; Айдаров, 1971: 353-354; Болд, 2000).

17. Сэврэйн бичээс

Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт эртний бичиг бүхий нэгэн чулуу байдаг тухай нутгийн багш залуу 1948 онд мэдээлсний дагуу тус аймгийн нутагт ажиллаж байсан палеонтологийн шинжилгээний ангийн ахлагч И.А.Ефремов бичээсийг үзэж улмаар шинжлэх ухааны эргэлтэд оруулахыг зорьжээ (Ефремов, 1962: 229). Хожим шинжлэн судлахад зориулж Б.Ринчен академич “Сэврэйн бичээс” гэж нэрлэн бичээсийн гэрэл зургийг хэвлүүлсэн байна (Rintchen, 1968). Сэврэйн чулууны руни бичээсийг эрдэмтэн С.Г.Кляшторный, японы эрдэмтэн А.Катаяма (Akio Katayama), доктор Ц.Баттулга нарын эрдэмтэд судлан уншлага, орчуулгаа хэвлүүлсэн байна (Кляшторный, Лившиц, 1971: 106-112; Kljaštornyj, Livšic, 1971: 11-20; Кляшторный, Лившиц, 1978: 57-59 (37-60); Takaо Moriyasu., 1999: 226-227; Баттулга, 2005: 158-161). Хөхөлбөр судалтай цагаан гантиг чулууг зориуд тэгшлэн засч толигор талд нь руни, согд бичээсийг гаргацтай, хичээнгүй, бичлэгийн хэв сайтай сийлжээ. Чулууны өндөр 80 см, бичигтэй талын өргөн 50 см, зузаан 60 см. Тэгшилж зассан толигор талд бичээс байх боловч он цагийн уртад нар салхи, цас борооны усанд идэгдэн үсэг тэмдэгт нь тун их бүдгэрч, сайн мэдэгдэхгүй болжээ.

18. Тайхар чулууны бичээс

Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунаа руни, согд, уйгур, монгол, дөрвөлжин, төвд, ланз, манж, тод, нангиад зэрэг арав гаруй зүйл үсэг бичгийн 200-аад дурсгал буй. Үсэг бичгийн эдгээр дурсгалаас хамгийн эрт үед холбогдох нь руни бичгийн дурсгал билээ.

Тайхар чулууны руни бичээсийг В.В.Радловоор удирдуулсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Д.А.Клеменц анх хуулбарлан авч “Хойд Тамирын бичээс” хэмээн нэрлэснээс хойш түүний судалгаанд тулгуурлан эрдэмтэд уншиж судалсан байна. Уул бичээсийг хамгийн анх В.В.Радлов уншиж судалсан ба түүнээс хойш Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун, С.Е.Малов, академич Б.Ринчен, нэрт түүхч Х.Пэрлээ, түрэг судлаач С.Харжаубай Туркийн эрдэмтэн О.Ф.Серткаягийн хамт, Б.Аззаяа нарын эрдэмтэд судалгааны бүтээлээ хэвлүүлсэн байна (Radloff, 1987: 260-268; Orhun, 1938: 107-123; Малов, 1959: 46-54; Rintchen, 1968: 34-36; Пэрлээ, 1960: 1-26; Sertkaya, Narcavbay, 2001: 313-346; Аззаяа, 2007: 68-74).

Бидний судалгаагаар Тайхар чулуунаа руни бичгийн 30 гаруй дурсгал бүртгэгдээд байгаа болно.

19. Тариат (Тэрх)-ын бичээс

Архангай аймгийн Тариат сумын төвөөс баруун тийш, Тэрхийн голын хойт биед, Долоон модны ам хэмээх газрын тушаа байсныг 1956 онд археологч Ц.Доржсүрэн анх олж илрүүлжээ (Доржсүрэн, 1958).

Мэлхий чулуунд суурилуулсан, 2 м гаруй урт (гурван хугархай нийлээд) энэ гэрэлт хөшөөг Тариатын гэрэлт хөшөө, Тэрхийн гэрэлт хөшөө гэж хоёр янзаар нэрлэсээр иржээ.

Уг гэрэлт хөшөөний бичээсийг М.Шинэхүү, Б.Базылхан, С.Г.Кляшторный, Т.Текин, А.Катаяма, С.Харжаубай, Л.Болд нар уншиж судалсан байна (Шинэхүү, 1974: 327-331; Шинэхүү, 1975: 219; Шинэхүү, 1980: 83; Базылхан, 1980: 163-175; Кляшторный, 82-95; Klyashtorny, 1983: 335-366; Tekin, 1982: 895-838; Tekin, 1983: 43-68; Такао Moriyasu, 1999: 168-176; Харжаубай, 2002: 32-52; Болд, 2000: 176).

20. Тариатын мэлхий чулууны бичээс

Тариатын гэрэлт хөшөөг тусгайлан зассан мэлхий чулуунаа суурилуулсан бөгөөд уг мэлхийний хуягны ирмэгийн дагуу нэг мөр руни бичиг, тамга буй. Тариатын гэрэлт хөшөөний бичээсийг судалсан эрдэмтэд мэлхий чулуун суурийн бичээсийг мөн судалсан байна.

21. Тэвшийн бичээс

“Тэвшийн түрэг бичээс” гэж нэрлэгдсэн, багахан чулуун дээрх бичээсийг анх 1949 онд Оросын эрдэмтэн А.Н.Окладниковын удирдсан хээрийн шинжилгээний анги олж илрүүлжээ. Б.Ринчен академич 1968 онд бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлснээр (Rintchen, 1968: 43) эл бичээсийн талаар анхны бодит мэдээ шинжлэх ухааны эргэлтэд орсон байна. Археологч Н.Сэр-Оджав (Сэр-Оджав, 1977: 141) уг бичигт чулууг Улаанбаатар хотод авчирсан бөгөөд эдүгээ ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа билээ.

Тэвшийн бичээс хоёр мөр, нэг тамганаас бүрдэх ба 54 х 42 см хэмжээтэй бор хүрэн өнгөтэй чулуунаа сийлэгджээ. Уг бичээсийн нэгдүгээр мөр 32 см, хоёрдугаар мөр 14 см орчим урт, тамганы өндөр 16 см, өргөн нь 16,5 см юм. Нэгдүгээр мөр бичээс 23, хоёрдугаар мөр бичээс 10 үсэг тэмдэгтээс бүрдэж байна. Хадны зурагт нийтлэг тохиолдох хонхойлгон цохиж цоолборлох аргаар зурсан, хүний зураг байх бөгөөд 13,5 см өндөр, 7 см өргөн юм.

Анх түрэг судлаач В.М.Наделяев, С.Харжаубай, академич Л.Болд, доктор Ц.Баттулга нарын эрдэмтэд судалгаагаа хэвлүүлжээ (Наделяев, 1974: 136-150; Харжаубай, 1979: 32-35; Болд, 1990: 110-112; Болд, 2000: 237-241; Баттулга, 2005: 178-181).

22. Тэсийн бичээс

Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс” судлалын хэсгийнхэн Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын Өвөр булгийн Хөх толгой хэмээх газраас Тэсийн гэрэлт хөшөөг анх олжээ (Харжаубай, Очир, 1976: 75).

Тэсийн гэрэлт хөшөөний бичээсийн бусад хугархай хэсэг олоогүйгээс бичээсийн бүрэн утга агуулгыг тодорхойлон өгүүлэхэд бэрхтэй юм.

С.Харжаубай, С.Г.Кляшторный, Т.Текин, Т.Оосава нарын эрдэмтэд уул бичээсийг уншиж судалсан байна (Харжаубай, 1979: 117-124; Klyashtorny, 1985: 137-156; Klyashtorniy, 1986: 151-171; Кляшторный, 1983: 76-90; Tekin, 1988: 111-118; Такао Moriyasu, 1999: 158-167).

Доктор Л.Болд бүтээлдээ уг бичээсийн судалгааны тойм хийгээд зарим үг хэллэгийн тухай өгүүлжээ (Болд, 1990: 113-117; Болд, 2000: 210-231).

23. Хангидайн хадны бичээс

Булган аймгийн Дашинчилэн сумаас баруун өмнө зүгт 27 км-т орших Хангидайн хадны бичээсийг О.Намнандорж гуай анх олж илрүүлсэн бөгөөд тэрээр “Арван өдрийн шинжилгээний ажлын тайлан”-даа “Булган аймгийн Дашинчилэн сумын Савангийн голын Хангидайн хаданд гурван мөр эртний түрэг бичээс буй” (Намнандорж, 1966: 38-41) хэмээн тэмдэглэсэн байна.

Б.Ринчен академич “Corpus Scriptorum Mongolorum” цувралдаа (Rintchen, 1968: 37) эл бичээсийн гэрэл зургийг нийтлүүлсэн ажээ. Б.Ринчен академичийн хэвлүүлсэн гэрэл зургийн эхэд тулгуурлан эрдэмтэн Б.Базылхан (Базылхан, 1990: 96-97) анх тайлж уншсан бөгөөд хожим С.Г.Кляшторный, М.Шинэхүү, Л.Болд нар судалсан байна (Кляшторный, 1975: 151-159; Кляшторный, 2006: 124-125; Шинэхүү, 1979: 65-69; Болд, 1990: 122-123). Ц.Баттулга Хангидайн хадны бичээсийг Хангай-Хэнтийн бүс нутаг дахь руни бичгийн судалгааны тоймд оруулсан (Баттулга, 2005: 75-76) ба 2006 онд судалгааныхаа үр дүнг нийтлүүлжээ (Баттулга, 2006А: 10-15).

24. Хар балгасын гэрэлт хөшөөний бичээс

Архангай аймгийн Хотонт сумын нутагт, Хархорин сумаас баруун хойш 45 км-т, Тан улсын Тянь баогийн 751 онд байгуулагдсан гэж сурвалж бичигт тэмдэглэгдсэн эртний Уйгур улсын нийслэл хотын туурь буй бөгөөд өдгөө Харбалгас хэмээн нэрлэнэ. Орду буюу Ханбалык хотын тууринд руни, согд, нангиад гурван зүйл үсгээр бичсэн гайхамшигт хөшөө байсныг Н.М.Ядринцев 1889 онд илрүүлснээр “Орхоны бичиг”-ийг анх нээсэн түүхтэй (Ядринцев, 1892а: 27-40; Ядринцев, 1892б; Ядринцев, 1901: 1-54).

Уг гэрэлт хөшөөний руни бичээсийг В.Радлов уншин тайлж бичээсийн үсэг, үгийн галиг хийж орчуулснаас гадна үгийн тайлбар толь хийж (Radloff, 1892; 1893; 1894, 1896; 1897, 1899), нангиад бичээсийг В.П.Васильевын уншсанаар бүтээлдээ оруулсан (Wassiljew, 1895; 1897; 1899: 286-291) ба уйгур (согд) бичээсийн талаар хараахан судалж амжаагүйг ч тодорхой дурдсан ажээ. Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун В.Радловын уншлага, галигийг хэвээр авч орчин цагийн турк хэлнээ орчуулсан байна (Orhun, 1936: 85). Манай эрдэмтдээс Ю.Болдбаатар, Л.Болд нар гэрэлт хөшөөний магнайн бичээсийг судалсан байна (Болдбаатар, 1997: 60-69; Болд, 2000: 51). Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд Т.Хаяаши, Т.Мориясу нар Харбалгасын археологийн шинжилгээ хийгээд холбогдох бусад сурвалжийн талаар тодорхой өгүүлж гэрэлт хөшөөний нангиад, согд, руни бичээсийг Т.Мориясу, Ю.Ёшида, А.Катаяма нар уншиж судалсан байна (Такао Moriyasu, 1999: 199-224). Хар балгасын хотын туурийг 1933-34 онд Д.А.Букинич, 1949 онд С.В.Киселев, Х.Пэрлээ нар малтан шинжилсэн бөгөөд тэдний Монголын эртний хот балгадын тухай бүтээлд туссан байна (Киселев, 1957: 91-101; Киселев, 1965; Пэрлээ, 1961: 46-52).

Хар балгасын хоёрдугаар бичээс

Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Уйгурын Хар балгасаас 8 орчим км холуур урсах Жарантай (Жирмэнтэй) голын хөвөөнөөс тус сумын сургуулийн түүхийн багш Мягмарсүрэн 1973 онд анх олсон бөгөөд 1975 онд Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан шинжилгээний ангийн бичээс судлалын хэсэг руни бичигтэй болохыг нь тогтоож улмаар 1976 онд Улаанбаатар хотод авчирсан байна.

М.Шинэхүү, Такаши Озава, Ц.Баттулга (Шинэхүү, 42-43; Takao Moriyasu, 1999: 143-145; Баттулга, 2005) нарын эрдэмтэд судалсан бөгөөд эдүгээ уг бичээс ихэд баларч хэдхэн тэмдэгт л үлдсэн байна.

25. Хутуг уулын түрэг бичээс

Таацын голын саваар хайгуул хийж явсан Германы геологичид илрүүлсэн гэх бөгөөд тэд Баянхонгор аймгийн нутгаас олсон хэмээн мэдээлжээ (Laur, 1972: 1-38).

Анх Е.Трыярски, Ж.Хамилтон нар, М.Шинэхүү, Ц.Баттулга нар уул бичээсийг уншиж судалсан дүнгээ нийтлүүлсэн ажээ (Tryjarski, Hamilton, 1975; Шинэхүү, 1976: 36-42; Баттулга, 2005).

26. Шаахарын I, II, III бичээс

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Шаахар толгой гэх газраас “Монголын түүх, соёлын дурсгалын сэдэвчилсэн лавлах” төслийн хүрээнд уг бичээсийг анх олж мэдээлсэн байна*. Таван үсэг тэмдэгтээс бүрдэх уул дурсгалыг судлаач Ю.Болдбаатар, Б.Напил, Ц.Баттулга нарын эрдэмтэд уншиж судалсан байна (Болдбаатар, 2001: 171-173; Базылханұлы, 2000: 77-78; Баттулга, 2005).

Эцэст нь дүгнэн тэмдэглэхэд, Нэгд; эдгээр дурсгалуудын байршил нь ихэвчлэн Монгол улсын баруун аймгуудын нутгаар ялангуяа авто зам дагуу байна.

Энэ нь авто замгүй газраар бичгийн дурсгал байхгүй гэсэн үг биш харин зүүн аймгуудын байгалийн тогтоц хад чулуу багатай байдагтай, нөгөө талаар эл бүс нутагт үсэг бичгийн дурсгалын хайгуул судалгаа бараг хийж байгаагүйтэй холбоотой байж болох юм.

Иймд, цаашид Монгол улсын нийт нутгаар үе шаттайгаар үсэг бичгийн дурсгалын хайгуул судалгаа хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Хоёрт; харьцангуй сайн судлагдсан гэх дээрх бичээсүүдийн судалгаа нь, ихэвчлэн археологичдын мэдээ, тайлан болон үсэг бичиг судлаачдын уншлага орчуулга төдийхнөөр хязгаарлагдсан байгааг анхаарууштай юм.

Тиймээс зөвхөн уйгурын үед холбогдох руни бичгийн дурсгал ч бус нийт бичгийн дурсгалуудыг хэл бичиг, түүх соёлын чухал дурсгал, бодит сурвалж бичиг болох талаас нь судлууштайг тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

Азаяа Б., 2007. Тайхар чулууны руни бичээс. -Acta Historica, Tom.VIII, fasc. 9, УБ.

Айдаров Г. 1971. Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века. Алма-Ата.

Базылхан Б., 1968. Хангидайн хадны түрэг бичээс (Хангидайская наскальная древнетюркская надпись Хангидайн хад). ШУА-ийн Мэдээ, №4, УБ. тал. 96-97.

Базылхан Б., 1969. Гурвалжин уулын түрэг бичээс. -ШУА-ийн мэдээ, № 4, тал. УБ. 14-15.

Базылхан Б., 1980. Тэрхийн түрэг бичээс. Studia Mongolica, Tom.VIII (16), fasc.12. УБ. тал.163-175.

